

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын ..... тоот албан бичгийн хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ  
2023 ОН

## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулж байна.

### **Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг хангах, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, бодлого, төлөвлөлтийг сайжруулах, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

### **Хоёр. Арга зүй**

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1-т заасан аргачлалаар буюу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хувиар илэрхийлэн үнэлсэн ба тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг мөн журмын 6.2.2-т заасан аргачлалаар тус тус үнэлсэн.

### **Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн**

#### **3.1. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний биелэлт**

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого, Хүний хөгжлийн бодлого, Эдийн засгийн бодлого, Засаглалын бодлого, Ногоон хөгжлийн бодлого, Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого гэсэн 6 бүлэг, 23 зорилго, 300 төсөл, арга хэмжээ тусгагдсан бөгөөд төлөвлөгөөний биелэлт 2022 оны жилийн эцсийн байдлаар **дунджаар 67.5 хувь** байна. Энэ нь 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилттэй харьцуулахад 19.4 хувиар өссөн байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 300 төсөл, арга хэмжээнээс 77 арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн буюу 100% биелэлттэй, 118 төсөл, арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99% биелэлттэй, 83 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-69% биелэлттэй, 22 арга хэмжээ үр дүнгүй буюу 0-29% биелэлттэй тус тус үнэлэгдлээ.


Төлөвлөгөөний биелэлтийг бодлого тус бүр болон биелэлтийн хувиар нэгтгэн харуулбал:

Хүснэгт 1. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний биелэлт

дд	Бодлого	Төсөл, арга хэмжээ	Биелэлтийн хувь										Дундаж үнэлгээ
			100	99-91	90	89-71	70	69-51	50	30	29-1	0	
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн				Эрчимжүүлэх шаардлагатай			Үр дүнгүй		
1	“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	8	5	1	1	-	-	-	-	1	-	-	89.3
2	Хүний хөгжлийн бодлого	80	23	-	9	1	21	-	9	7	-	10	66.5
3	Эдийн засгийн бодлого	115	20	1	8	5	30	5	14	22	3	7	61.2
4	Засаглалын бодлого	53	13	-	7	1	15	-	9	7	-	1	70.1
5	Ногоон хөгжлийн бодлого	20	3	-	2	-	9	2	3	-	-	1	69.0
6	Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	24	13	-	4	-	3	-	2	2	-	-	84.5
<b>Нийт</b>		<b>300</b>	<b>77</b>	<b>2</b>	<b>31</b>	<b>7</b>	<b>78</b>	<b>7</b>	<b>37</b>	<b>39</b>	<b>3</b>	<b>19</b>	<b>67.5</b>

Төлөвлөгөөнд тусгагдсан бодлого тус бүрийн хэрэгжилтийг харьцуулан авч үзэхэд, “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого 89.3%, нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого 84.5% хэрэгжсэн байгаа нь бусад бодлоготой харьцуулахад, биелэлт 17.8-22.6% илүү байна.

График 1. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлт /үндсэн 6 бодлогоор/



Төлөвлөгөөний биелэлтийг хариуцсан байгууллагаар нь авч үзвэл, Батлан хамгаалах яам 82.0%, Барилга, хот байгуулалтын яам 82.0%, Сангийн яам 80.0%, Боловсрол, шинжлэх ухааны яам 77.0%, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 80.0% хувь, Стандарт, хэмжил зүйн газар 75.0% хувийн биелэлттэй байгаа нь бусад яам, агентлагаас илүү гүйцэтгэлийн өндөр хувьтай байна.

График 2. Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний биелэлт /байгууллагаар/



Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлтээс “0” хувийн биелэлттэй дараах 19 төсөл, арга хэмжээ байгаа ба энэ нь ЭМЯ /7/, ЗТХЯ /5/, СоЯ /2/, ХНХЯ /1/, УУХҮЯ /1/, БХБЯ /1/, СЯ /1/, БОАЖЯ /1/ тус тус хариуцсан арга хэмжээ байна. Үүнд:

- 2.1.1.Зүрх судасны төвийн барилгын ажлыг эхлүүлэх /ЭМЯ/;
- 2.1.2.Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлыг эхлүүлэх; Төв ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн тооцооллыг хийх /ЭМЯ/;
- 2.1.3.Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх /ЭМЯ/;
- 2.1.21.“Элэг бүтэн Монгол” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, элэгний делта вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах /ЭМЯ/;
- 2.1.25.Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II-ыг байгуулах ажлыг эхлүүлэх /ЭМЯ/;
- 2.1.28.Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ыг байгуулах ажлын зураг, төсвийг боловсруулах /ЭМЯ/;
- 2.1.32.Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барих /ЭМЯ/;
- 2.2.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажлыг эхлүүлэх /ХНХЯ/;
- 2.6.2.Үндэсний номын сангийн шинэ барилгыг бүрэн ашиглалтад оруулах /СоЯ/;
- 2.6.3.Соёлын өвийн бүртгэл, хяналтын системийг хөгжүүлж, мэдээллийн санг бүрдүүлэх /СоЯ/;
- 3.2.21.Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах /УУХҮЯ/;
- 3.6.9.Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замыг эхлүүлэх /ЗТХЯ/;

3.6.23.Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замыг барих /ЗТХЯ/;

3.6.24.Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замыг барих ажлыг эхлүүлэх /ЗТХЯ/;

3.6.25.Хэнтий аймгийн Норовлин-Дорнод аймгийн Баян-Уул-Ульхан боомт чиглэлийн 124 км хатуу хучилттай авто замыг барих /ЗТХЯ/;

3.6.29.Сүхбаатар аймгийн Баруун-Урт-Эрдэнэцагаан-Бичигт боомт чиглэлийн тусгай зориулалтын авто замын барилгын ажлыг эхлүүлэх /ЗТХЯ/;

3.7.1. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх /БХБЯ/;

4.3.15.Хилийн боомт дахь улсын байцаагчдыг хүнсний бараа, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох түргэвчилсэн багаж хэрэгслээр хангаж, эрсдэл өндөртэй бараа, бүтээгдэхүүний илрүүлэлтийг нэмэгдүүлэх /СЯ/;

5.1.8.Цаг уурын бодит болон цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлэх /БОАЖЯ/.

Эдгээр төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй шалтгааныг авч үзвэл, санхүүжилт, хөрөнгө оруулалт шийдэгдээгүй /6/, тендер шалгаруулттай холбоотой /3/, арга хэмжээ, хүрэх түвшинг судалгаа үндэслэлтэй, эрсдэлийг тооцож оновчтой төлөвлөөгүй /3/, шүүхийн маргаантай /1/ зэрэг шалтгаантай байгаагийн зэрэгцээ тайлан ирүүлээгүй /1/, мөн ажил эхлүүлээгүй, удаашралтай, шалтгаан тодорхой бус /5/ арга хэмжээ байна.

### 3.2. Санхүүжилтийн гүйцэтгэл

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд 300 төсөл, арга хэмжээг 11,714.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үүний 18.4%-ийг улсын төсвийн хөрөнгөөр, 23.3% гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр, 25.2% концесс болон төр-хувийн хэвшлийн түншлэлээр, 32.1% төр-хувийн хэвшлийн түншлэлээр, 1.1% орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нийт 4,141.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийсэн нь нийт төлөвлөсөн дүнгийн 35.4%-ийг эзэлж байна.

Хүснэгт 2. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр

Санхүүжилтийн эх үүсвэр	Санхүүжилт төлөвлөсөн арга хэмжээний тоо	Төлөвлөсөн /сая төгрөг/	Санхүүжилт авсан арга хэмжээний тоо	Гүйцэтгэл /сая төгрөг/
Улсын төсөв	161	2,155,095.2	80	1,172,286.3
Гадаадын зээл, тусламж	62	2,725,264.6	40	1,796,523.8
Концесс, ТХХТ	20	2,946,099.1	1	40,000.0
Төр-хувийн хэвшлийн түншлэл	13	3,761,252.2	8	1,034,202.9
Орон нутгийн төсөв	6	126,290.0	2	29,199.9
Тусгай сан	-	-	4	69,063.3
<b>Нийт</b>	<b>262</b>	<b>11,714,001.1</b>	<b>135</b>	<b>4,141,276.3</b>

Нийт санхүүжилтийн 43.4% буюу 40 төсөл, арга хэмжээг гадаадын зээл, тусламжаар, 28.3% буюу 80 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр, 25.0% буюу 8 төсөл, арга хэмжээг төр-хувийн хэвшлийн түншлэлээр, 1.7% буюу 4 төсөл,

арга хэмжээг Засгийн газрын тусгай сангийн эх үүсвэрээр, 1.0% буюу 1 төсөл, арга хэмжээг концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн эх үүсвэрээр, 0.7% буюу 2 төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвөөр санхүүжүүлсэн байна.

Санхүүжилтийг төсөвлөсөн нийт 262 арга хэмжээний 63.4% буюу 166 арга хэмжээнд санхүүжилт хийгдээгүй байна. Тухайлбал, “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд төлөвлөсөн санхүүжилтийн 80%, Засаглалын бодлогын 95.7%, Хүний хөгжлийн бодлогын 61.2%, Эдийн засгийн бодлогын 61.5%-д санхүүжилт тус тус хийгдээгүй байна.

Эх үүсвэр тусгагдаагүй 38 төсөл, арга хэмжээнээс 8 төсөл, арга хэмжээг 126.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлснээс 66.3% буюу 83.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөр, 32.9% буюу 41.6 тэрбум төгрөгийг гадаадын зээл, тусламжаар, 0.8% буюу 1.0 тэрбум төгрөгийг төр-хувийн хэвшлийн түншлэлээр санхүүжүүлжээ.

Хүснэгт 3. Санхүүжилтийн гүйцэтгэл /Хэрэгжүүлэгч байгууллагаар/

д/д	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Арга хэмжээний тоо	Төлөвлөсөн дүн /сая төгрөг/	Гүйцэтгэл дүн /сая төгрөг/	Төлөв/Гүйц (%)
1	ЗГХЭГ	5	4,500.0	-	-
2	ЭЗХЯ	3	380.0	-	-
3	ГХЯ	3	725.0	44.20	6.10
4	СЯ	5	296,020.0	296,000.00	99.9
5	ХЗДХЯ	18	115,063.0	10,099.40	8.8
6	БОАЖЯ	27	319,493.7	91,397.80	28.6
7	БХЯ	5	22,830.0	-	-
8	БХБЯ	20	577,159.9	289,258.4	50.1
9	БШУЯ	27	559,591.8	219,624.6	39.2
10	ЗТХЯ	37	3,260,359.8	249,481.2	7.7
11	СоЯ	7	15,662.0	25,827.1	164.9
12	УУХУЯ	21	2,535,477.7	1,652,841.6	65.2
13	ХНХЯ	13	44,380.0	69,645.7	156.9
14	ХХААХҮЯ	19	154,268.6	86,675.1	56.2
15	ЦХХХЯ	13	25,840.0	-	-
16	ЭХЯ	20	2,059,140.2	320,135.1	15.5
17	ЭМЯ	37	207,513.5	548,251.7	264.2
18	ОБЕГ	1	94,050.0	-	-
19	ШӨХТГ	2	16.0	-	-
20	МХЕГ	2	850.0	-	-
21	СХЗГ	2	800.0	-	-
22	БТСУХ	2	28,400.0	-	-
23	ТӨБЗГ	2	71.0	300.3	422.96
24	НЗДТГ	5	1,216,815.9	281,694.0	23.15
25	БСАА	2	174,533.0	-	-
26	ЖҮХ	2	60.0	-	-
<b>Нийт</b>		<b>300</b>	<b>11,714,001.1</b>	<b>4,141,276.25</b>	<b>35.4</b>

## Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд 6 бүлэг, 23 зорилгод хамаарах нийт 300 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас 2022 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт дунджаар **67.5** хувийн биелэлттэй үнэлэгдсэн бөгөөд “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-д заасан ангилалд шилжүүлэн тооцвол, нийт арга хэмжээний 25.7% буюу 77 арга хэмжээ 100% хэрэгжсэн байгаа нь төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хангалтгүй, төлөвлөлт оновчтой бус байгааг харуулж байна.

Хүснэгт 4.Төсөл, арга хэмжээний дундаж үнэлгээ

Ангилал	Үнэлгээ	Арга хэмжээний тоо	Нийт арга хэмжээнд эзлэх хувь /%/
Үр дүнтэй	100%	77	25.7
Тодорхой үр дүнд хүрсэн	70-99%	118	39.3
Эрчимжүүлэх шаардлагатай	30-69%	83	27.7
Үр дүнгүй	0-29%	22	7.3
Дүн		300	

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд 300 төсөл, арга хэмжээг 11.7 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 35.4% буюу 4.1 их наяд төгрөгийн санхүүжилтийг хийсэн нь хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлыг бодитой үнэлж төлөвлөлт хийгээгүй, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх урьдчилсан шатны ажлууд удаашралтай явагдаж байгаатай холбоотой байна.

Төлөвлөгөө нь суурь болон зорилтот түвшинг тодорхойлсон үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй бөгөөд тайлан ирүүлсэн байгууллагуудаас Эрчим хүчний яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа, холбооны яам болон НЗДТГ-аас зарим төсөл, арга, хэмжээний хэрэгжилтийг журмын 6.2.1-т заасан аргачлалаар үнэлсэн, бусад байгууллагууд журмын 6.2.2-т заасан аргачлалыг ашигласан байна.

### Тав. Санал

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

#### Төлөвлөлтийг оновчтой болгох талаар:

1.Салбарын чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, түүний хүрэх үр дүнг төлөвлөхдөө урьдчилсан судалгаа, үнэлгээг хийж, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц, шат дараалал, хэрэгжих хугацаа, гарах үр дүн, өмнөх жилийн гүйцэтгэл, тулгарсан асуудал зэргийг нарийвчлан судалж, төсөл, арга хэмжээ болон түүний хүрэх түвшинг оновчтой, тодорхой төлөвлөх;

2.Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсөвт бүрэн тусгах;

3.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл, арга хэмжээг боловсруулахад үндсэн болон хамтрагч байгууллагууд оролцож, хамтран ажиллах хүрээ, хязгаарыг нарийн тохирох;

### Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар:

1.Төсвийн ерөнхий захирагч нар хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн хариуцан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган ажиллах, хэрэгжилт хангалтгүй төсөл, арга хэмжээг дараа жилийн төлөвлөгөөнд тусгаж бүрэн хэрэгжүүлж дуусгах;

2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга Монгол Улсын хөгжлийн бодлого, Засгийн газрын дэвшүүлсэн бодлого, зорилтын хүрээнд төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, холбогдох асуудлыг хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэж ажиллах;

### Тайлагналтыг сайжруулах талаар:

1.Төрийн байгууллагуудын бодлогын хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг журмаар тодорхой зохицуулах;

2.Төлөвлөгөөнд үндсэн хэрэгжүүлэгчээр батлагдсан байгууллага нь хамтран хэрэгжүүлэгч байгууллага тус бүрээс хэрэгжилтийн тайлан болон санхүүгийн гүйцэтгэлийг авч нэгтгэн ирүүлж байх;

3.Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний [www.new.unelgee.gov.mn](http://www.new.unelgee.gov.mn) мэдээллийн цахим системд хэрэгжилтийн тайланг оруулахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхой тусгаж, нотлох баримтыг хавсарган, иж бүрэн тайлагнах, мөн хагас жилийн болон жилийн эцсийн тайланд санхүүжилтийн гүйцэтгэлийг оруулахдаа дүнг сайтар нягталж, жилийн эцсийн байдлаарх өссөн дүнг хагас жилийн гүйцэтгэлтэй сайтар тулгаж, зарцуулалтыг бүрэн гүйцэд тайлагнаж байх;

4.Яам, байгууллагаас өөрийн үйл ажиллагаандаа хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан хянаж үзэх зэрэг болно.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР